

ЧИНГИС ХААНААС ЧАН ЧУНЬ БУМБАД ХАРАГЧИН ХОНИН ЖИЛИЙН ЕС ДҮГЭЭР САРЫН ХОРИН ДӨРВӨНИЙ ӨДӨР ИЛГЭЭСЭН ЗАРЛИГ

Ц. Ганбаатар. МУИС. МХСС-ийн Гадаад хэлний тэнхимийн багш

П. Дэлгэржаргал. МУИС. НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш

Өгүүллийн товч утга: Энэ удаа бид Чингис хаанаас Чан Чунь бумбад харагчин хонин жил (1223)-ийн ес дүгээр сарын хорин дөрвөний өдөр илгээсэн нэгэн зарлигийг орчуулан, эрдэм шинжилгээний тайлбар хийн хэвлүүлж байна.

Түлхүүр үг: Зарлигийн элч, Чингис хааны зарлиг, Чю сахиус, гэрээс гарах, бумба болох.

Чингис хаанд уригдан алс холоос очиж уулзсан мэргэдийн нэг нь Чан Чунь бумба билээ. Чингис хаантай биеэр уулзан ярилцаж, түүний ярьж хэлсэнийг тэмдэглэн үлдээсэн зохиол бүтээл ховор байдаг. Харин Чан Чунь бумбыг дагалдан явсан шавь Ли Жичань “Чан Чунь бумбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл” хэмээх бүтээлийг бичиж үлдээжээ. Иймээс судлаачид Чингис хаан ба Чан Чунь бумба хоёрын уулзалтын талаар ихэд сонирхон, судлан шинжилж, үнэлэлт дүгнэлт өгсөн нь олонтоо байна.

“Тэдний зарим нь зэрлэг Чингис утга гэгээн, хятад бумбатай чухам яах гэж уулзаж ярилцсаныг ихэд гайхцгаасан” байдаг бол, “зарим нь Чингис Чан Чунь бумбаас зөвхөн мөнхжүүлэх эм гуйх зорилгоор урьсан” гэж тайлбарласныг академич Ш.Нацагдорж “энэ бол гүехэн мэдлэгтэй хүмүүсийн дэмий балай чалчаа үгээс хэтрэхгүй юм” хэмээн няцаагаад “... улсыг засах, иргэнийг жолоодох талаар хятадын гүн ухаантан эрдэмтэнтэй харилцан санал солилцож зөвлөх гэсэн хэрэг”¹ хэмээн оновчтой тайлбарласан байдаг.

Чан Чунь бумба нь 1148 онд Хятадын Шаньдун мужид төржээ. Даосийн шашны Чуаньзиндао урсгалын долоон тэргүүлэгчдийн нэг² бөгөөд тэрбээр Даогийн сургаалийг залгамжлагчдын дунд төдийгүй буддист болон күнзийнхний дунд асар их алдаршсан Даосын даяанч байсан³. Тухайн үедээ үнэний мөрийг олж, нас уртасган, амь мөнхжүүлэх арга ухаанд хүрсэн хүн гэж нийт Хятад даяар алдаршжээ.

¹ Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ., 1991. т.195

² 辭海 (Үгийн далай). 上海. 1979. 78 頁.

³ Клеменць Д.А. Замътки къ маршруту Чанъ-чуня. Сборник в честь семидесятилетия Г.Н. Потанина //Зап.ИРГО. по отд. этнографии. –СПб., 1909. Т.34. с. 446

Байлдан дагуулсан суурин иргэншилтэй орнуудыг баримтлан захирах талаар Чингис хааны явуулсан бодлогыг судлахад их хаанаас Чан Чунь бумбад илгээсэн захидал, зарлиг зэрэг нь чухал хэрэглэгдэхүүн болно. Чингис хаан үнэхээр мөнхжүүлэх эм гуйхаар Чан Чунь аршийг урьсан уу, эсвэл улсыг засах, иргэнийг жолоодох талаар харилцан санал солилцон зөвлөж, даосийн шашинтнуудыг өөртөө татах зорилгыг агуулж байсан уу гэдгийг Чингис хаанаас Чан Чунь аршид илгээсэн зарлигуудаас тодруулж болох юм. Өрнөдийн судлаачдын үздэгчлэн Чингис хаан "мөнхжүүлэх эм гуйхаар" урьсан бол Чан Чунь арштай уулзсанахаа дараа түүний сүм хийд, шавь нарыг алба, гувчуураас чөлөөлж, тэнгэрийн доорх даосийн сургаалтнуудыг захирах эрх олгох шаардлагагүй байсан. Чингис хааны эдгээр зарлигийн цаад учир шалтгааныг даосийн шашинтнуудыг өөртөө татах зорилготой байсан гэж тайлбарлах нь түүхэн үнэнд илүү нийцнэ хэмээн үзэж байна.

"Чан Чунь бумбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл" зохиолоос гадна Чингис хаанаас Чан Чунь бумбыг урьсан захидлууд, Чан Чунь бумбаас Чингис хаанд илгээсэн захидал, Чингис хаанаас Чан Чунь бумбад илгээсэн захидал, зарлиг зэрэг хэд хэдэн эх материал одоогоор бидэнд олдоод байна. Эдгээрээс монгол хэлнээ орчуулагдаагүй зарим материалыг орчуулан, эрдэм шинжилгээний тайлбар хийн нийтийн хүртээл болгохыг бид зорьж байгаа бөгөөд энэ удаа Чингис хаанаас Чан Чунь бумбад илгээсэн харагчин хонин жилийн (1223 он) ес дүгээр сарын хорин дөрвөний өдрийн нэгэн зарлигийг та бүхэнд толилуулж байна.

Уг зарлиг нь нийт 9 мөр, 83 хятад ханз бүхий бичээстэй, 1 дүгээр мөрний "зарлигийн элч", 2 дугаар мөрний "Чингис хаан", 7 дүгээр мөрний "Чю богд сахиус" гэсэн үгүүдийг мөр тэтгэн бичсэн байна.

Зарлигийн бичээст хөшөө эдүгээ Шаньси мужийн Жоужа дахь "Чун Яны Түмэн наст сүм"-ийн арын хашаанд хадгалагдаж байна. БНХАУ-ын Улсын номын сан болон Бээжингийн их сургуулийн номын санд уг хөшөөний хэв дардас хадгалагдаж байгаа болно. Энэхүү зарлигийн эх "Соёлын өв" сэтгүүлийн 1986 оны №5-ын 10-11 дэх талд⁴ гэрэл зургаар хэвлэгдсэнийг хавсаргав.

⁴ 图片出自《文物》1986年第5期,页10—11

一二二三年整屋重陽萬壽宮聖旨碑

Зарлигийн хятад бичээс:

- [1] 宣差阿裏鮮面奉
[2] 成吉思皇帝聖旨：丘神仙奏
[3] 知來底公事，是也煞好。我
[4] 前時已有聖旨文字與你
[5] 來，教你天下應有底出家
[6] 善人都管着者，好底歹底，
[7] 丘神仙你就便理會，只你識
[8] 者。奉到如此。
[9] 癸未年九月二十四日

yīèrèrsān nián zhōuzhì chóngyáng wànshòu
gōng shèngzhǐ bēi

Зарлигийн хятад бичээсийн галиг:

- [1] xuānchā A Lǐxiān'miàn fèng
[2] Chéngjísī huángdì shèngzhǐ qiū shénxiān zòu
[3] zhīláidǐ gōngshì shiyě shā hǎo wǒ
[4] qián shí yǐyǒu shèngzhǐ wénzì yǔ nǐ
[5] lái, jiào nǐ tiānxià yīngyǒu dǐ chūjiā
[6] shànrén, dōu guǎn zhùzhě hǎodǐ dǎidǐ,
[7] Qiū shénxiān nǐ jiù biàn lǐhuì, zhī nǐ shí
[8] zhě. Fèngdào rúcǐ.
[9] guǐ wèi nián jiǔ yuè èrshísì rì

Жоужи дахь Чун Яны Түмэн наст бумбын
ордон [сүм]⁵-д байгаа 1223 оны Чингис хааны
зарлигийн хөшөөний бичээс⁶

Зарлигийн түшмэл А Ли-сянь⁷ нүүрдэн [биеэр] айлтгасан [дамжуулсан] Чингис хааны зарлиг:

Чю⁸ богд сахиусын⁹ айлтган мэдүүлэхээр ирүүлсэн албан хэрэг маш сайн. Би урд өмнө нь нэгэнтээ хаан эзний зарлигийн бичгийг¹⁰ чамд өгсөн билээ. Тэнгэрийн

⁵宮 (gong) гэсэн үг нь "ордон" гэсэн утгатай боловч даосийн шашинд "сүм"-ийг ингэж нэрлэдэг. (Cleaves F.W. The Sino-Mongolian inscription of 1240. Harvard Journal of Asiatic Studies, Vol.23. (1960-1961), p. 68). Чун Яны түмэн наст сүм (重陽萬壽宮) нь Алтан улс, Юань улсын үед хүчтэй сэргэн мандаж байсан Даогийн шашны Чуаньжэндао урсгалыг үндэслэгчдийн гурван том ордны нэг юм. Хуучин Жоужи сяньд харьяалагдаж байсан бөгөөд одоогийн Шаньси мужийн Хусянь-аас баруун тийш арваад км-т байна. Алтан улсын үеийн Даосийн Чуаньжэндао урсгалыг үндэслэгч Ван Зи (сахилын нэр Чун Ян-зы, 1112-1170)-ийн даяан (бясалгал) хийж, ёс мөрд суралцсан газар бөгөөд түүнийг тэнгэр хальсны дараа шарилыг нь авчирч нутаглуулсан газар болно. Анхны нэр нь "дээдсийн сүм", Алтан улсын Чэн Ань-ы 4 дүгээр он буюу 1199 онд дахин засварлаад Линьсюгуань гэж нэрлэжээ. Алтан улсын сүүлээр цэрэг дайны хөлд эвдэгдээд Юань-ий эхэн үед дахин сэргээн босгосон. Тайзунгийн 10 дугаар он буюу 1238 онд "Ван Чоу гүн" буюу "Түмэн наст сүм" хэмээн нэрлэгджээ. 1245 онд дахин "Чун Яны Түмэн наст сүм" нэртэй болжээ.

⁶ Энэхүү хөшөө нь Шаньси мужийн Жоужи дахь "Чун Яны Түмэн наст сүм"-ийн арын хашаанд байдаг. Шэнзунюаний (Мөнх хааны оны цол) тэргүүн он, цагаачин гахай жил буюу 1251 онд уг бичээст хөшөөг босгожээ. БНХАУ-ын Улсын номын сан болон Бээжингийн их сургуулийн номын санд уг хөшөөний хуулбар хадгалагдаж байна. (Одоо Улсын номын санд хадгалагдаж байгаа хуулбарын дугаар: 2559). Мөн одоогийн Шаньдун мужийн Чиндао-ийн Лаошань уулнаа буй Даогийн Тайчингүн сүмд хадгалагдаж байна. (這石刻保存山東青島嶗山太清宮).

⁷ Чингис хааны анхны заллагын бичгийг зарлигийн түшмэл Лю Жун-лү авчирч Чан Чунь бумбад гардуулсан бөгөөд хэдэн сарын дараа буюу 1919 оны X сарын үед **А Ли-сянь** нь Отчигины ордноос Чан Чунь бумбыг залахаар очиж уулзсан байна. Энэ талаар "А Ли-сянь их ван Отчигины ордноос багшийг залахаар ирэв" (王國維 校注. 長春真人西游記. 19頁) хэмээн тэмдэглэжээ. Мөн энэ сард Чан Чунь бумбаас Чингис хаанд илгээсэн айлтгал бичгийг хүргэж, хариу авч ирсэн элч Хала буцаж ирсэн бөлгөө. **А Ли-сянь**-ийг Чан Чунь бумбыг Чинис хаантай уулзах хүртэл дагалдан явсан гэж үзэж болох юм. "Жэнтун даозан" (正統道藏) хэмээх номын 57 дугаар ботийн 46225 талд "Зарлигаар багшийг дагалдан хамгаалж явсан Монголын талын дөрвөн хүмүүн хэмээн Монгудай, Хэлибахай, зарлигийн элч **А Ли-сянь**, зарлигийн элч Лю Жун-лү нарыг тэмдэглэсэн байна. (《正統道藏》, 台北艺文印书馆1977年影印本, 第57册, 侍行門人. 頁46225; 党寶海. 長春真人西游記. 河北人民出版社. 2001. 134頁). **А Ли-сянь**-ийг зарлигийн элчээр томилсон талаар "Чан Чунь бумбын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл"-д "**А Ли-сянь**-ийг зарлигийн элчээр томилон, түүний туслахаар Монгудай, Хэлибахай нарыг өгч, багшийг хамгаалан зүүн тийш хүргэж өгөхийг зарлиг болгов" (王國維 校注. 長春真人西游記. 95-96頁) хэмээн өгүүлсэн байна. Дөжүүрийн орчуулгаар ӨМСХХ-ноос хэвлэн гаргасан "Чан Чунь бумбын баруунш зорчсон тэмдэглэл" зохиолд **А Ли-сянь**-ий нэрийг **Рашаан** гэж бичсэн байна. ("Чан Чунь бумбын баруунш зорчсон тэмдэглэл. ӨМСХХ. 1993. т. 29, 145). Монгол хэлний "Р" үсгийг хятад хэлэнд "Л"-ээр эхэлсэн үеэр галигладаг уламжлалыг баримталвал **А Ли-сянь**-ий нэрийг **Рашаан** гэж буулгаж болох юм.

⁸ Эцэг багш бумба Чан Чунь-зы овог Чю, нэр Чу-зы, өргөсөн нэр Тунми, Дэнжоу тойргийн Сися газар (одоогийн Шандун муж)-ын хүн. Тэтэмлээгүй гэрээс гарч (20 нас хүрээгүй) Чун-ян бумбад шавь оржээ. (王國維 校注. 長春真人西游記. 1頁). Чю Чу-зы (1148-1227) Даосийн шашны Чуаньжэндао урсгалын долоон тэргүүлэгчдийн нэг. Чун-яныг таалал төгссөний дараа Лунмэншань

дор буй бүхий л гэрээс гарч¹¹ бумба бологсдыг чи хамааран мэд. Сайн хийгээд мууг, Чю богд сахиус, зөвхөн та л мэдэгтүн хэмээлээ. Үүний тул айлтган дамжуулав.

Харагчин хонин жилийн¹² IX сарын 24-ний өдөр


ууланд даяан бясалгал хийж, Лунмэний урсгалыг үндэслэсэн. Чингис хаантай уулзаж, Богд сахиус цолтой болжээ. Түүний шавь Ли Жи-чань "Чан Чунь бумбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл" зохиолыг бичиж үлдээжээ. Алтан улс болон Сун улсаас удаа дараа элч илгээн урьсан боловч очоогүй. Харин Юань Тайзугийн 14 дүгээр он буюу 1219 онд Чингис хааны урилгыг элч Лю Жун-лү авчирсан учир 1219 онд 18 шавиа дагуулан Чингис хаантай уулзахаар гарч, гурван жил аялан явж, Дундад Азийн Их цаст уул (одоогийн Афганистаны Хиндү Күш уул)-ын ард хүрэлцэн очиж 1222 онд Чингис хаантай уулзжээ. Юань Тайзугийн 19 дүгээр он буюу 1224 онд Яньзин (одоогийн Бээжин) хотод буцаж ирээд Их Тяньчангуань сүмд сууж байжээ. Чингис хаан барсын толгойт алтан гэрэгэ болон тамгат бичиг олгож, тэнгэрийн доорх даосийн шашинтангуудыг захирах зарлиг гаргаж, түүнчлэн даосийн сүм хийд хийгээд гэрээс гарч бумба бологсдыг алба гувчуураас хэлтрүүлэх зарлиг гаргажээ. Чань Чун бумба Юань Тайзугийн 22 дүгээр он буюу 1227 оны VII сард 80 настайтай өвчнөөр таалал болжээ. (辭海 (Үгийн далай). 上海. 1979. 78 頁).

⁹ "Богд сахиус" (神仙) гэдэг нь үгийг "Орчин цагийн хятад хэлний толь бичиг"-ийн 1124 дэх талд домогт гардаг тоост орчлонгоос ангижирсан, мөнх наст, хэтийдсэн чадвартай хүмүүнийг хэлнэ хэмээн тайлбарлажээ. (現代漢語詞典. 北京. 2003. 1124 頁). "Юань ши"-ийн 202 дугаар бүлэг дэх "Чю Чу-зы-ийн намтар"-т "Түүнээс [Чингис хаан] барсын толгойт пайз [гэрэгэ] өгч, бас хааны хас тамгат бичиг дагалдуулан багшийн уг нэрийг эс тэмдэглэн, гагц **Богд сахиус** хэмээв" (元史. 202 卷. 中華書局出版發行. 北京. 2005. 4525 頁) гэснээс үзэхэд Чингис хаанаас Чан Чуньд "Богд сахиус" (神仙) цол хүртээсэн ажээ.

¹⁰ Энд Чингис хаанаас Чан Чунь бумбад илгээсэн харагчин хонин жилийн (1223 он) III сарын зарлигийн талаар өгүүлж байна. "Чан Чунь бумбын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл"-д энэхүү зарлигийн талаар "III сарын 7-ны өдөр багш буцах явдлаа дахин айлтгасанд: Эзэн хаан үхэр, морь зэрэг зүйлийг бэлгэнд барив. Гэвч багш тэдгээрийг хүртэхээс татгалзаж, зөвхөн агт унаа байвал хангалттай хэмээв. Хаан орчуулагч **А Ли-сянь**-аас Нанхиад газарт богд сахиусын шавь олон эсэхийг асуув. **А Ли-сянь** хариу: олон бөлгөө хэмээгээд, Богд сахиусны ирэх үед Дэсинь-фу ордны Луньяньгуань сүмд албан яамнаас алба гувчуурыг байнга хурааж байсныг олж харсан гэв. Хаан хэлсэн нь: "Тэгвэл тэднийг алба гувчуураас чөлөөлөх нь зүйтэй" хэмээгээд хааны эрдэнэ (хааны тамга) бүхий зарлигийн бичгийг хайрлав". (王國維 校注. 長春真人西游記. 95-96頁) хэмээн энэхүү зарлигийн бичгийн талаар өгүүлсэн байна. Чан Чунь бумбын шавь нарыг алба татвараас чөлөөлсөн уг зарлигийг чулуунд сийлэн, Шэнзунюаний (Мөнх хааны оны цол) тэргүүн он, цагаачин гахай жил буюу 1251 онд бичээст хөшөөг босгожээ. Энэхүү хөшөө нь Шаньси мужийн Жоужидахь "Чун Яны Түмэн наст сүм"-ийн арын хашаанд байдаг. БНХАУ-ын Улсын номын сан болон Бээжингийн их сургуулийн номын санд уг хөшөөний хуулбар хадгалагдаж байна. (Одоо Улсын номын санд хадгалагдаж байгаа хуулбарын дугаар: 2559). Энэхүү зарлигийн эх 《正統道藏》, 台北艺文印书馆1977年影印本, 第57册, 46223頁 хэвлэгдсэн болно. Энэхүү зарлигийн бичиг ШУА-ын Түүхийн Хүрээлэнгийн "Түүхийн судлал"-ын боть XXXVI (2006)-д Монгол орчуулга тайлбартайгаар хэвлэгдсэнээс үзнэ үү.

¹¹ "Үгийн далай"-ын 1095 дахь талд "Гэрээс гарах" гэдэг нь бурхны шашны хэллэг. Гэрээ орхин сүмд очиж хувраг болохыг зааж байгаа болно. Энэтхэгээс анх уламжлан гарч, бурхны шашин дэлгэрсэнээс хойш уг хэллэгийг хэрэглэх болжээ. Даогийн шашны Чуаньжэн урсгалд даосуудын сүмд шавилан суухыг "гэрээс гарах" гэж хэлдэг гэжээ. (辭海. 上海. 1979. 1095 頁).

¹² Харагчин хонин жил (癸未年 *guīwèi nián*) нь 1223 он болно. Энэ нь Өмнөд Сун улсын Зядин (Jiading)-ийн 16 дугаар он, Алтан улсын Юаньгуань (Yuanguang)-ы 2 дугаар он юм. (辭海 (Үгийн далай). 上海. 1979. 2126-2127 頁).



Ном зүй.

1. 元史. 中華書局出版發行. 北京. 2005
2. 王國維 校注. 長春真人西游記. “蒙古史料校注”本 (1926 年清華學校研究院排 印本)
3. 党寶海. 長春真人西游記. 河北人民出版社. 2001
4. 朱燿廷. 成吉思汗全傳. 北京出版社. 1998
5. 辭海. 上海. 1979
6. 卿希泰, 唐大潮 著. 道教史. 中國社會科學出版社. 北京. 1994
7. 《文物》1986年第5期。
8. 《長春真人西游記》附錄, 《正統道藏》, 台北藝文印書館1977年影印本, 第57冊, 頁 46223—46225。
9. Arthur Waley. The travels of an Alchemist, the Journey of the Taoist Chang —Chun from China to the Hindukush at the Summons of Chingiz Khan, London, 1931
10. Bretshneider E. Medieval researches from eastern Asiatic sources, Vol I, London, 1910; Reprinted Taipei, 1991

11. Cleaves F.W. The Sino-Mongolian inscription of 1240. Harvard Journal of Asiatic Studies, Vol.23. (1960-1961), pp. 62-75
12. Баясах Ж. Их Монгол улсын түүхэнд холбогдох Хятад хоёр сурвалж бичиг. УБ., 2006
13. Клеменцъ Д.А. Замътки къ маршруту Чанъ-чуня. Сборник в честь семидесятилетия Г.Н.Потанина //Зап.ИРГО. по отд. этнографии. –СПб.,1909. Т.34.
14. Мункуев Н.Ц. Китайский источник о первых Монгольских ханах. Москва, 1965
15. Мункуев Н.Ц. Монголын анхны хаадын тухай Хятад эх сурвалж. (Орос хэлнээс орчуулсан Ч.Баатар). УБ., 2004
16. Мункуев Н.Ц. Мэн-да бэй-лу (“полное описание монголо-татар”). Москва, 1975
17. Нацагдорж Ш. Чингис хааны цадиг. УБ., 1991
18. Сайшаалт. Чингис хааны товчоон. Доод дэвтэр. ӨМАХХ. 1988
19. Си Ю Цзи или описание путешествия на запад даосского монаха Чан Чуня. -Универсальный Международный альманах “Арабески истории” вып. 2. “Пустыня Тартари. Москва, 1995. 280-378
20. Чан Чунь бумбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл. (Хятад хэлнээс орчуулсан Н.Ариунгуя). УБ., 1997

Abstract: In this case (time) we translated the edict, which was sent to Chang Chun from Chinggis khaan in the year of black sheep 24th of September 1223, and made a research commentary on it and printed.